

**“ЮАНЬ УЛСЫН СУДАР” ДАХЬ
ЧАН ЧУНЬ БУМБЫН НАМТАР**

Ц. Ганбаатар. Могол улсын их сургуулийн Монгол хэл соёлын сургууль.

П. Дэлгэржаргал. Монгол улсын их сургуулийн Нийгмийн шинжлэх ухааны сургууль. Түүхийн тэнхим
Deegii2001mn@yao.com

Өгүүллийн товч утга: “Юань ши”-ийн 202 дугаар бүлэгт (олон шастирын 89 дүгээр бүлэг) есөн хүний намтар байгаагийн дотор Чю Чу-зы (Чан Чунь бумба)-ын намтрыг орчуулан, тайлбар хийн нийтэлж байна.

Түлхүүр үг: Чю Чу-зы, Чан Чунь бумба, Тай-зу Чингис хаан, барсын толгойт пайз

Даосийн шашны Чуаньзиндао урсгалын долоон тэргүүлэгчдийн нэг Чан Чунь бумба нь 1148 онд Хятадын Шаньдун мужид төржээ¹. Тэрбээр Даогийн сургаалийг залгамжлагчдын дунд төдийгүй буддист болон күнзийнхний дунд асар их нэр хүндийг олж², тухайн үдээ үнэний мөрийг олж, нас уртасган, амь мөнхжүүлэх арга ухаанд хүрсэн хүн гэж нийт Хятад даяар алдаршжээ.

Чан Чуь бумба Чингис хааны урилгыг 1219 онд хүлээн аваад нутгаас гарч аялан явсаар, 1222 оы IV сарын 5 (билгийн тооллын)-нд Хиндү Күш уулын ар хормойд зусаж байсан Чингисхааны нүүдэл ордонд ирж түүнтэй анх уулзжээ.

Чингисхаантай биеэр уулзан ярилцаж, түүний ярьж хэлсэнийг тэмдэглэн үлдээсэн зохиол бүтээлхвор байдаг. Харин Чан Чунь бумбыг дагалдан явсан шавь Ли Жи-чань “Чан Чунь бумбын өрнө этгээдэд зорчсон тэмдэглэл” хэмээх бүтээлийг бичиж үлдээжээ.

Судлаанд Чингис хаан ба Чан Чунь бумба хоёрын уулзалтын талаар ихэд сонирхон, судан шинжилж үнэлэлт дүгнэлт өгсөн нь олонтоо байна. “Тэдний зарим нь зэрлэг Чингис утга гэгээн, хятад бумбатай чухам яах гэж уулзаж ярилцсаныг ихэд гайхцгаасан” айдаг бол, “зарим нь Чингис Чан Чунь бумбаас зөвхөн мөнхжүүлэх эм гуйх зорилгоор урьан” гэж тайлбарласныг академич Ш.Нацагдорж “энэ бол гүехэн мэдлэгтэй хүмүүсийн дэий балай чалчаа үгээс хэтрэхгүй юм” хэмээн няцаагаад “... улсыг засах, иргэнийг жолодох талаар хятадын гүн ухаантан эрдэмтэнтэй харилцан санал солилцож зөвлөх гэсэн хрэг”³ хэмээн оновчтой тайлбарласан байдаг.

Чингисхаан суурин иргэншилтэй улсуудыг байлдан дагуулаад, тэдгээр орныг баримтлан захирахдаа шашны элдэв төлөөлөгчид, эрдэмтэн мэргэдийн талаар ихээхэн нарийн бодлоо явуулж, тэднийг өөртөө татаж, төрийн хэрэгт туслалцуулж байжээ. Монголоос өө ахуй соёл, зан заншил, уламжлал, шашин шүтлэг бүхий олон аймаг, угсааны суури иргэдийг эрхэндээ оруулж, баримтлан захирч, түвшитгэн тохинуулахад тэдгээр орны рдэмтэн мэргэдийн санал бодол, заавар зөвлөгөөг өргөн ашиглаж, шашны урсгалуудыг өртөө татаж, тэдний дэмжлэгийг авахад Чингис хаан ихээхэн анхаарал тавьж байжээ.

“Чан Чнь бумбын өрнө этгээдэд зорчсон тэмдэглэл” зохиолоос гадна Чингис хаанаас Чан Чунь бумбыг урьсан захидлууд, Чан Чунь бумбаас Чингис хаанд илгээсэн захиал, Чингис хаанаас Чан Чунь бумбад илгээсэн захидал, зарлиг зэрэг хэд хэдэн эх мтериал одоогоор бидэнд олдоод байна. Эдгээрээс монгол хэлнээ орчуулагдаагү зарим материалыг орчуулан, эрдэм шинжилгээний тайлбар хийн нийтийн хүртээл болгсыг бид зорьж, Чингис хаанаас Чан Чунь бумбад илгээсэн харагчин хонин жилийн (1223он) III сарын нэгэн зарлиг, мөн оны ес дүгээр сарын хорин дөрвөний

¹ 辭海 (Үгийн длай). 上海. 1978. 33 頁.

² Клеменць Д.Азамьтки къ маршуту Чань-чуныя. Сборник в честь семидесятилетию Г.Н. Потанина/Зап.ИРГО. по отд. этнографии. –СПб., 1909. Т.34. с. 446

³ Ш.НацагдоржЧингис хааны цадиг. УБ., 1991. т. 195

өдрийн бас нэгэн зарлигийг бид Монгол хэлнээ орчуулан, тайлбар хийн нийтлүүлсэн билээ⁴.

Байлдан дагуулсан суурин иргэншилтэй орнуудыг баримтлан захирах талаар Чингис хааны явуулсан бодлогыг судлахад их хаанаас Чан Чунь бумбад илгээсэн захидал, зарлиг зэрэг нь чухал хэрэглэгдэхүүн болно. Чингис хаан үнэхээр мөнхжүүлэх эм гуйхаар Чан Чунь аршийг урьсан уу, эсвэл улсыг засах, иргэнийг жолоодох талаар харилцан санал солилцон зөвлөж, даосийн шашинтнуудыг өөртөө татах зорилгыг агуулж байсан уу гэдгийг Чингис хаанаас Чан Чунь аршид илгээсэн зарлигуудаас тодруулж болох юм. Өрнөдийн судлаачдын үздэгчлэн Чингис хаан "мөнхжүүлэх эм гуйхаар" урьсан бол Чан Чунь арштай уулзсанахаа дараа түүний сүм хийд, шавь нарыг алба, гувчуураас чөлөөлж, тэнгэрийн доорх даосийн сургаалтнуудыг захирах эрх олгох шаардлагагүй байсан. Чингис хааны эдгээр зарлигийн цаад учир шалтгааныг даосийн шашинтнуудыг өөртөө татах зорилготой байсан гэж тайлбарлах нь түүхэн үнэнд илүү нийцнэ хэмээн үзэж байна.

Чан Чунь бумбын намтар, Чингис хааны шашны талаар явуулсан бодлого, Чингис хаан Чан Чунь бумбын хоорондын харилцаа зэргийг тодруулахад Юань ши дахь Чань Чунь бумбын намтар нь чухал ач холбогдолтой.

Энэ удаад бид "Юань ши"-ийн 202 дугаар бүлэгт (олон шастирын 89 дүгээр бүлэг) есөн хүний намтар байгаагийн дотор Чю Чу-зы (Чан Чунь бумба)-ын намтрыг орчуулан, тайлбар хийж та бүхэнд толилуулж байна.

“Юань улсын судар” дахь Чан Чунь бумбын намтрын орчуулга⁵

Чю Чу-зы⁶, Дэн Жоу-ын [газрын] Сися⁷ [нутгийн] хүн. Өөрийн цол нь Чан Чунь-зы⁸. Бага балчир үед нь зурхайч түүнийг хожмын өдөр Богд сахиус (арш) шүтээний багш болно хэмээв. Арван есөн насандаа Чуаньжэн⁹-ийн сургаалд орж, Нинхай газрын Кунюй шань¹⁰ ууланд Ма Юй, Тан Чу-дуань, Лю Чу-шуань, Ван Чу-и, Хао Да-тун, Сун Бү-ер нартай хамт Ван овогт Чун Ян¹¹ бумбын дор шавилав. Чун Ян багш бээр уулзсан даруйдаа Чу-зыг ихэд хүндээр үзжээ. Алтан, Сун улсын үед цөм элч түшмэл илгээж, урьсан боловч

⁴ Чингис хаанаас Чан Чунь бумбад илгээсэн харагчин хонин жилийн нэгэн зарлиг. //Түүхийн судлал. Том. XXXVI, F.7, УБ., 2006.т. 47-54, Чингис хаанаас Чан Чунь бумбад харагчин хонин жилийн есдүгээр сарын хорин дөрвөний өдөр илгээсэн зарлиг. //МУИС-ийн НШУС-ийн ЭШБ. Түүх. VI. №279(39). УБ., 2007. 27-32 дэх талыг үзнэ үү.

⁵ “Юань ши”-ийн 202 дугаар бүлэгт (олон шастирын 89 дүгээр бүлэг) есөн хүний намтар байгаагийн дотор Чю Чу-зы (Чан Чунь бумба)-ын намтар багтсан байна. 元史. 中華書局出版發行. 北京. 2005. 4524-4526 頁.

⁶ Эцэг багш бумба Чан Чунь-зы овог Чю, нэр Чу-зы, өргөсөн нэр Тунми. Тэтгэмлээгүй гэрээс гарч (20 нас хүрээгүй) Чун-ян бумбад шавь оржээ (王國維 校注. 長春真人西游記. 1 頁) хэмээн “Чан Чунь бумбын баруун этгээдэд зорчсон тэмдэглэл”-д өгүүлснээс үзэхэд түүний уг нэр нь Чю Чу-зы болох нь тодорхой байна. Чю Чу-зы (1148-1227) Даосийн шашны Чуаньжэндао урсгалын долоон тэргүүлэгчдийн нэг. Чун-яныг таалал төгссөний дараа Лунмэншань ууланд даяан бясалгал хийж, Лунмэний урсгалыг үндэслэсэн.

⁷ Чан Чунь бумба Дэнжоу тойргийн Сися газар (одоогийн Шандун муж)-т төржээ.

⁸ Чю Чу-зыгийн сахилын нэр нь Чан Чунь-зы юм. Чан Чунь бумба нэрээрээ алдаршсан.

⁹ Чуаньжэн гэдэг Дао шашны нэгэн урсгал бөгөөд Чан Чунь бумбын багш Чун-ян нь Алтан улсын Дадингийн 7 дугаар он буюу 1167 онд Шаньдун мужийн Нинся хэмээх газар Чуаньжэн урсгалыг үндэслэжээ. (辭海 (Үгийн далай). 上海. 1979. 314 頁) Чуаньжэндао гэдэг нь төгс төгөлдөр үнэн ёс гэсэн утгатай бөлгөө.

¹⁰ Чанчунь бумбын гэрээс гарч бясалгал даяан хийсэн уулын нэр. Одоогийн Шаньдун мужийн Нинхай хэмээх газар буй

¹¹ Дао-ийн Чуаньжэн урсгалыг үндэслэгч Чун-ян нь Чан Чунь бумбын багш юм.

эс очив¹². Шар туулай жил¹³ Тай-зу¹⁴ бээр Найман аймгийн нутагт¹⁵ шадар түшмэл За Ва – ег¹⁶, Лю Жун-лү¹⁷ нарт зарлигийн бичиг¹⁸ бариулж, түүнийг урин залав. Чу-зы нэгэн өдөр гэнэт шавь нартаа захиж хувцас хунар бэлтгүүлээд, “тэнгэрийн элч мөхөс надад зарлигаа [жоу бичиг] илгээж, би бээр үтэр мордсугай” хэмээв. Маргааш нь хоёр хүн хүрч ирэхэд Чу-зы арван найман шавиа¹⁹ авч хамтаар уулзахаар мордов. Ирэх жил нь Шаньбэй газар хүрээд морьтныг илгээж, айлтгал бичиг²⁰ бариулан алж хядахыг зогсоох болов уу гэж чин сэтгэлээр ятгав. Бас дараа жил нь заллагын элч дахин хүрч ирсэнд²¹ Фүжоугаас мордож, хэдэн арван улсыг өнгөрөн түм гаруй газар аялав. Цус урсгасан дайны талбараар өнгөрөн,

¹² Чанчүнх бомбо 1188 онд, мөн 1211 онд тус тус Алтан улсад заллагаар очиж, шашны ёс буян номын ажил хийж байжээ. Гэвч түүнээс хойш Алтан улс, өмнөд Сүн улсын элч нар удаа дараа ирж урин залсан боловч очоогүй ажээ.

¹³ Шар туулай жил нь нийтийн тооллын 1219 он. Өмнөд Сүн улсын Зядин (Jiading)-ийн 12 дугаар он, Алтан улсын Синдин (xingding)-на 3 дугаар он юм. (辭海 (Үгийн далай). 上海. 1979. 2126 頁)

¹⁴ Чингис хааны оны цолыг хятадаар Тай-зу гэж нэрлэдэг. Тай-зугийн тэргүүн он 1206 оноос эхлэнэ. Тай-зу-ийн 1-22 дугаар он нь 1206-1227 он болно.

¹⁵ Чан Чунь бумбын баруун этгээдэд зорчсон тэмдэглэл зохиолд “Лю Жин-лү тэр жилийн 5 дугаар сард Найманы ордонд эзний зарлигийг хүээн авсан” (王國維 校注. 長春真人西游記. 6頁) хэмээн дурдсан байдаг. Н.Ариунгуа “Найманы орд Идэрийн голын эрэг хавиар байрлаж байсан” гэж үзсэн байна. (Чан Чунь бумбын өрнө зүгт зорчсон тэмдэглэл. УБ., 1997. т.72)

¹⁶ Ван Говэй түүнийг Чингис хааны ойрын шадар хүмүүсийн нэг байсан гэжээ. Юань улсын судар¹⁷-ын 129-р ботид буй Жафар ход-жагийн намтарт: “Их хаан \Чингис хаан\ хойд нутагтаа байгаа Жафарыг бусад жанжуудын хамт Жундү-г хамгаалуулахаар үлдээсэн ба ерөнхий даругачи хэмээх албан тушаалыг түүнд олгожээ. Тэрээр Хуанхө Шар мөрөн\-өөс хойш Төмөр хаалганаас урагш орших бүх газар нутгийг бүхэлд нь хамаарч байсны дээр насан өндөр болохын цагт нь амин тэжээлийг нь дааж байх 100 өрх айл болон Алтан улсын язгууртнуудын орд харшнаас түүнд өгсөн байлаа” хэмээн тэмдэглэжээ.

Жундү хотыг Монголчууд 1215 оны 5 срд эзэлж авсан гэдгийг бодоод үзэхэд Монголын их эзэн хаан эзэлж авсан орнууддаа даругачи нарыг томилсон явдал хамгийн эртдээ 1215 он бололтой.

“Мэн-да бэй-лү”-гийн зохиогч нь Жафар ходжаг 1221 он хүртэл Яаньжинд даругачийн албанд байсан хэмээн өгүүлж байгаагаар Умард Хятадыг захирахад түүнийг оролцож байсан гэсэн “Юань улсын судар”-т тэмдэглэгдсэн баримтыг баталж буй юм.

¹⁷ Лю Жун-лү 劉仲祿 дуут сум хийхдээ гарамгай нэгэн байжээ. Чингис хааны эмчээр ажиллаж байгаад Найманы ордонд Чан Чунь бумбыг урих заллагын бичгийг хүргэх элчээр томилогдон, хорь гаруй хүн дагуулан явж Чан Чунь бумбатай уулзан Чингис хааны урилгыг гардуулсан байна. Чан Чунь бумба Чингис хаантай уулзсаны дараа их хааны зарлигийг хүргэх элчээр томилогдон Чан Чунь бумбыг дагалдан явжээ. (党寶海. 長春真人西游記. 河北人民出版社. 2001. 7頁; 王國維 校注. 長春真人西游記. 3-4頁).

¹⁸ Лю Жун-лү Найманы ордонд Чан Чунь бумбыг урих заллагын бичгийг хүргэх элчээр томилогдон, хорь гаруй хүн дагуулан явж Чан Чунь бумбатай уулзан Чингис хааны урилгыг гардуулсан байна. (王國維 校注. 長春真人西游記. 6頁). Чингис хаанаас Чан Чунь бумбыг урьсан анхны заллагын бичиг (Жао бичиг 詔書) академич Н.Ишжамцын орчуулгаар “Өрнө Дорно” сэтгүүлд хэвлэгдсэнээс үзэж болно. (Ишжамц Н. Чингис хаан Хятадын эрдэмтэн Чан Чунь бумбыг урьж уулзсан нь. Дорно Өрнө. № 2 [33]. УБ., 1993. т. 41-48)

¹⁹ Бомбын шашны ганжуур болох Жэньтун Даозан хэмээх сударт Чанчүнх бомбыг дагалдан явсан 18 шавийн нэрс, мөн тусгай зарлигаар хамгаалан явсан 4 монгол хүний нэр тэмдэглэгджээ.

²⁰ Чан Чунь бумбаас Чингис хаанд илгээсэн айлтгал бичгийг хүргэж, хариу авч ирсэн элч Хала буцаж ирсэн бөлгөө. Энэ талаар “Чан Чунь бумбын баруун этгээдэд зорчсон тэмдэглэл” зохиолд “Багш [Чан Чунь] Ваншань ууланд зугаалж явах үеэр Чингис хаан руу довтолгосон элч Хала буцаж ирэв” (王國維 校注. 長春真人西游記. 21頁) хэмээн тэмдэглэжээ.

²¹ Чингис хааны анхны заллагын бичгийг зарлигийн түшмэл Лю Жун-лү авчирч Чан Чунь бумбад гардуулсан бөгөөд хэдэн сарын дараа буюу 1919 оны X сарын үед А Ли-сянь нь Отчигины ордноос Чан Чунь бумбыг залахаар ирсэн тухай энд өгүүлж байна. Энэ талаар “А Ли-сянь их ван Отчигины ордноос багшийг залахаар ирэв” (王國維 校注. 長春真人西游記. 19頁) хэмээн тэмдэглэжээ.

хулгай дээрмээс сэргийлж зайлан хоол ундгүй, элс манхныг туулан, Кунюйгээс мордож дөрвөн жилийн нүүрийг үзэж, Цаст ууланд²² хүрэв. Хүлэг морьд үргэлж гүн цаснаа явна. Цасны гүн нь морин дээрээс ташуур өргөн хэмжихэд хунгарласан цасны хагаст ч хүрэхгүй. Тай-зу [Чингис хаан]-д золгоход, Тайзу ихэд баясч, идээ ундаа хайрлаж, майхан цацар босгон машид хүндэтгэв. Энэ үед Тай-зу яг барууншаа дайлан, өдөр бүр байлдан дайтаж байсан цаг тул Чу-зы дэлхий дахиныг (тэнгэрийн доорх) олсугай хэмээвээс эрхбиш алж хядахыг багасгах хэрэгтэй болохыг үгүүлэв. Төрийг засах ёсыг асуухад тэнгэрт сүсэглэн иргэдийг хайрлахыг үндэс болговол зохино хэмээн өчив. Мөнх наслахын ёсыг асуухад сэтгэлийг ариутган, хүслийг багасгахаас (тэвчвээс) чухал хэмээн айлтгав. Тай-зу түүний үгийг гүн ухаж үгүүлрүүн, “тэнгэрээс сахиусан өвгөн таныг надад хүртээж (хайрлаж) мөхөс миний сэтгэлийг сэргээв” хэмээгээд хойшид хөвгүүддээ сургахын тусад дэргэдэх түшмэдэд захиж үсэг бичгээр тэмдэглүүлэн авав. Түүнээс барсын толгойт пайз [гэрэгэ] өгч, бас хааны хас тамгат бичиг дагалдуулан багшийн уг нэрийг эс тэмдэглэн, гагц “Богд сахиус” хэмээв. Нэгэн өдөр тэнгэр дуугарч аянга нэжигнэхүйд Тай-зу учрыг асуусанд: Чу-зы өчсөн нь: “Аянга бол тэнгэрийн сүр буюу. Хүмүүний ял, нүгэлд ачлал тахимдуу үгүйгээс хүнд ял гэж үгүй. Ачлалгүй бол тэнгэрийн санаанд үл нийлнэ. Тийнхүү тэнгэрийн сүр хүчээр сэрэмжлүүлмүй. Сонссоноор улсын дотор эцэг эхээ ачлахгүй хүмүүн олон буй хэмээх юм. Эзэн та тэнгэрийн сүрийг ухуулан мэдүүлж, олон иргэдийг сургаваас сайн буюу” хэмээв. Тайзу түүнийг зөвшөөрөн дагав. Харагчин хонин жил Тайзу Дуншань (Зүүн уул) уулнаа их ав талибахуйд унасан морь нь бүдэрч, мориноос ойчсоныг Чу-зы эзэнд “тэнгэрийн ёсон хүмүүнийг амьдруулмуй. Эзэн таны насан сүүдэр өндөр болсон тул урт холдоо олонтаа авалваас үл зохимуй” хэмээн айлтгасанд Тай-зу дахин ав хийхийг удтал зогсов. Тэр тухайд улсын цэрэг (хааны их цэрэг) Жунюань²³-ийг дайран цохиж Хэнань, Хэбэйг байлдан дайрсан нь нэн хэцүү. Ард иргэд алж хядагдан баривчлагдаж, амь гарах аргагүй болцгоожээ. Чу-зы бээр Янь²⁴ [Яньзин]-д буцаж ирээд шавь нартаа тамгат пайз бариулж, байлдааны завсар чөлөөнд зарим боол бологсод дахин сайн иргэд бологсод, усанд харайн биеэ хорлохоор шуудсан, дахин амьдрах замыг хөөгсөд хоёр гурван түмээр ч зогсохгүй. Ийнхүү Жунжоу²⁵ орны хүмүүс эдүгээ болтол энэ явдлыг дурсан яримуй. Хөхөгчин тахиа жил²⁶ Ангараг гариг одон Фэймэй одонд халдаж Яньжингийн хязгаарт гамшиг болоход Чу-зы бээр сацал санваар үйлдэн ариутгал хийсэнд Ангараг гариг үнэхээр ухармой. Улаагчин гахай жил²⁷ дахин бас ган гачиг болсон учраас бороо хур гуйн сацал санваар үйлдсэн гурав дахь өдөрт нь үнэхээр бороо хур оров. Ийнхүү эзний зарлигаар сүмийн нэрийг Чан Чунь ордон²⁸ [сүм] хэмээн нэрлэхийн зэрэгцээ элч түшмэл илгээн Чу-зы-ийн мэндийг асуулгаж “мөхөс би үргэлж болд сахиусыг дурсмуй. Богд сахиус та битгий намайг мартагтун” хэмээв. Зургаадугаар сард Дунзи горхиноо биеэ угаав. Хоёр өдрийн дараа тэнгэр дуугарч их бороо орж, Тайюй цөөрмийн ус эргээ хальж, хойд зүгтээ урсаж Дунху нуурт оров. Ус урсах дуун хэдэн газар хол сонсдож, загас жараахай мэлхий цөмөөр урсан одож, цөөрөм даруйдаа хоосорч, хойд амны эрэг дэлбэчин нурсанд Чу-зы шүүрс алдан “уул нурмуй, ус хатмуй, миний бие хамт одмуй”

²² Одоогийн Афганистан улсын нутагт байх Хинду Күш хэмээх уул. Чан Чунь бумба 1222 оны 4 сарын 5-нд Хинду Күш уулын ар хормойд зусаж байсан Чингис хааны нүүдэл ордонд ирж түүнтэй анх уулзжээ.

²³ Дотор газар буюу Хятад газрыг ийн нэрлэдэг ажгуу. Үүнд Шар мөрний доод урсгал орчмын нутаг буюу одоогийн Хэнань мужийн газар нутгийн ихэнх хэсэг, Шаньдун мужийн баруун хэсэг, Хэбэй, Шааньси мужийн өмнөд хэсгийн газар нутаг багтана.

²⁴ Одоогийн Бээжин хотыг хэлж байна.

²⁵ Дотор газар буюу Хятад газрыг ийн нэрлэж байна.

²⁶ Хөхөгчин тахиа (乙酉yǐyōu) жил нь нийтийн тооллын 1225 он. (辭海 (Үгийн далай). 上海. 1979. 2126頁).

²⁷ Улаагчин гахай (丁亥dīnghai) жил нь нийтийн тооллын 1927 он. (辭海 (Үгийн далай). 上海. 1979).

²⁸ Одоогийн Бээжин хотод байх Бумбын шашны Цагаан үүлийн сүм юм. Тухайн үед Их эзэн хаан Чингисийн зарлигаар Чан Чунь ордон (сүм) хэмээн нэрлэсэн ажээ.

хэмээгээд даруй наян настай насан нөхцөв²⁹. Түүний шавь И Жы-фэн зэрэг хүмүүс эзний тамгат бичгийг барьж сургаалыг нь залгамжлан үргэлжлүүлжээ. Хожим нь Жи-дагийн үед³⁰ алтан тамга олгов.

丘處機，登州棲霞人，自號長春子。兒時，有相者謂其異日當爲神仙宗伯。年十九，爲全真學于寧海之崑崙山，與馬鈺、譚處端、劉處玄、王處一、郝大通、孫不二同師重陽王真人。重陽一見處機，大器之。金、宋之季，俱遣使來召，不赴。

歲己卯，太祖自乃蠻命近臣札八兒、劉仲祿持詔求之。處機一日忽語其徒，使促裝，曰：「天使來召我，我當往。」翌日，二人者至，處機乃與弟子十有八人同往見焉。明年，宿留山北，先馳表謝，拳拳以止殺爲勸。又明年，趣使再至，乃發撫州，經數十國，爲地萬有餘里。蓋躑躅血戰場，避寇叛城，絕糧沙漠，自崑崙歷四載而始達雪山。常馬行深雪中，馬上舉策試之，未及積雪之半。既見，太祖大悅，賜食，設廬帳甚飭。

太祖時方西征，日事攻戰，處機每言欲一天下者，必在乎不嗜殺人。及問爲治之方，則對以敬天愛民爲本。問長生久視之道，則告以清心寡欲爲要。太祖深契其言，曰：「天錫仙翁，以窮朕志。」命左右書之，且以訓諸子焉。於是錫之虎符，副以璽書，不斥其名，惟曰「神仙」。一日雷震，太祖以問，處機對曰：「雷，天威也。人罪莫大於不孝，不孝則不順乎天，故天威震動以警之。似聞境內不孝者多，陛下宜明天威，以導有衆。」太祖從之。

歲癸未，太祖大獵于東山，馬路，處機請曰：「天道好生，陛下春秋高，數敗獵，非宜。」太祖爲罷獵者久之。時國兵踐蹂中原，河南、北尤甚，民罹俘戮，無所逃命。處機還燕，使其徒持牒招求於戰伐之餘，由是爲人奴者得復爲良，與濱死而得更生者，毋慮二三萬人。中州人至今稱道之。

歲乙酉，焚惑犯見，其占在燕，處機禱之，果退舍。丁亥，又爲旱禱，則以三日雨。當名瑞應，已而亦驗。有旨改賜宮名曰長春，且遣使勞問，制若曰：「朕常念神仙，神仙毋忘朕也。」六月，浴于東溪，越二日天大雷雨，太液池岸北水入東湖，聲聞數里，魚鱉盡去，池遂涸，而北口高岸亦崩。處機嘆曰：「山其摧乎，池其涸乎，吾將與之俱乎！」遂卒，年八十。其徒尹志平等世奉璽書襲掌其教，至大間加賜金印。

Юань ши. Бээжин, 2005. 202 дугаар бүлэг. 4524-4525 дахь талаас авав.

Ном зүй.

²⁹ Чань Чун бумба Юань Тайзугийн 22 дүгээр он буюу 1227 оны VII сард 80 настайдаа өвчнөөр таалал болжээ. (辭海 (Үгийн далай). 上海, 1979. 78 頁).

³⁰ Жида (至大 zhida) нь Юань гүрний Хайсан Хүлэг хааны оны цол. Жидагийн үе нь нийтийн тооллын 1308-1311 оныг хамаарна. (辭海 (Үгийн далай). 上海, 1979. 2128 頁).

1. 元史. 中華書局出版發行. 北京. 2005
2. 王國維 校注. 長春真人西游記. “蒙古史料校注”本 (1926 年清華學校研究院排印本)
3. 党寶海. 長春真人西游記. 河北人民出版社. 2001
4. 朱燿廷. 成吉思汗全傳. 北京出版社. 1998
5. 辭海. 上海. 1979
6. 卿希泰, 唐大潮 著. 道教史. 中國社會科學出版社. 北京. 1994
7. 《長春真人西游記》附錄, 《正統道藏》, 台北藝文印書館1977年影印本, 第 57冊,
46223—46225頁。
8. Arthur Waley. The travels of an Alchemist, the Journey of the Taoist Chang – Chun from China to the
Hindukush at the Summons of Chingiz Khan, London, 1931
9. Bretshneider E. Medieval researches from eastern Asiatic sources, Vol I, London, 1910; Reprinted Taipei,
1991
10. Баясах Ж. Их Монгол улсын түүхэнд холбогдох Хятад хоёр сурвалж бичиг. УБ., 2006
11. Богд баатар биеэр дайлсан тэмдэглэл. (орчуулсан Асралт, Хөх-Өндөр) ӨМСХХ.1985
12. Ганбаатар Ц. Дэлгэржаргал П. Чингис хаанаас Чан Чунь бумбад илгээсэн харагчин хонин жилийн нэгэн
зарлиг. //Түүхийн судлал. Том. XXXVI, F.7, УБ., 2006 (хамт). 47-54
13. Ганбаатар Ц. Дэлгэржаргал П. Чингис хаанаас Чан Чунь бумбад харагчин хонин жилийн есдүгээр сарын
хорин дөрвөний өдөр илгээсэн зарлиг. //МУИС-ийн НШУС-ийн ЭШБ. Түүх. VI. №279(39). УБ., 2007. т.
27-32
14. Ганбаатар Ц. Дэлгэржаргал П. The meeting of Chinggis khaan and Chan Chun Bumba. –“The Current
Situation and Perspectives of Middle East and Northeast Asia” сэдэвт олон улсын хуралд тавьсан илтгэл.
УБ., 2008
15. Клеменць Д.А. Замъеткикъ маршруту Чанъ-чуня. Сборник в честь семидесятилетия Г.Н.Потанина
//Зап.ИРГО. по отд. этнографии. –СПб., 1909. Т.34.
16. Ишжамц Н. Чингис хаан Хятадын эрдэмтэн Чан Чунь бомбыг урьж уулзсан нь. Дорно Өрнө. № 2
[33]. УБ., 1993. 41-48
17. Мункуев Н.Ц. Китайский источник о первых Монгольских ханах. Москва, 1965
18. Мункуев Н.Ц. Монголын анхны хаадын тухай Хятад эх сурвалж. (Орос хэлнээс орчуулсан
Ч.Баатар). УБ., 2004
19. Мункуев Н.Ц. Мэн-да бэй-лу (“Полное описание монголо-татар”). Москва, 1975
20. Нацагдорж Ш. Чингис хааны цадиг. УБ., 1991
21. Рачневский П. Чингис хаан: түүний амьдрал, өв. (Англи хэлнээс
орчуулсан Л.Мөнх-Эрдэнэ). УБ., 2006.
22. Сайшаалт. Чингис хааны товчоон. Доод дэвтэр. ӨМАХХ. 1988
23. Си Ю Цзи или описание путешествия на запад даосского монаха Чан
Чуня. –Универсальный Международный альманах “Арабески истории” вып. 2. “Пустыня
Тартари. Москва, 1995. 280-378
24. Чан Чунь бумбын өрнө зүгт зорчсон тэмдэглэл. (Хятад хэлнээс орчуулсан Н.Ариунгуа). УБ., 1997